



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/501

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн зорчигч тээвэр, аймаг, сум хоорондох хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан хот хоорондын авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, Арвайхээр сумын хэмжээнд хяналтын постод үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, хяналтын постод ажиллах алба хаагчдын ариутгал, халваргүйжүүлэлт, бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулах 3,847,000 (гурван сая найман зуун дөчин долоон мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101119

Аймгийн Засаг даргын 2020 оны.....
 дүгээр сарын-ны өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖИХ ХҮРЭЭНД
 ШУУРХАЙ ШТАБ, ХЯНАЛТЫН ПОСТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЛБА
 ХААГЧДЫН ХООЛ ХҮНС, ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

1. Шатахуун

Д/д	Зарцуулагдах төрөл	Шатахууны төрөл	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж /литр/	Нийт үнэ
1	Постод үүрэг гүйцэтгэх автомашин	АИ-92	1400	1 170	1,638,000
2	Замын хяналт тавих автомашин	АИ-92	1400	710	994,000
		ДТ	1900	200	380,000
3	Постны хөдөлгөөнт хяналтын цэг байрлуулах	АИ-92	1400	280	392,000
4	Постуудад хяналт шалгалт	АИ-92	1400	100	140,000
Дүн					3,544,000

2.Түлээ, нүүрс

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Мод	шуудай	39	5000	195,000
Дүн					195,000

3. Бичиг хэрэг

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Бичгийн цаас	боодол	4	12,000	48,000
2	Принтерийн хор	Ширхэг	1	60,000	60,000
Дүн					108,000